



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/618

Булган сум

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Олимп, Дэлхий, Тив, Олон улс, Үндэсний спорт, Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдад урамшуулал олгох журам” батлах тухай ХХ/08 дугаар тогтоол, 2024 оны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/69 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Парис хотноо зохион байгуулагдсан ОМС Hairworld “World Cup-2025” тэмцээнд амжилттай оролцож Дэлхийн аварга болсон Булган аймгийн үсчин Нэргүйн Амгаланбаатар, Улаанбаатар хотноо 2025 оны 06 дугаар сарын 23-29 ний хооронд зохион байгуулагдсан “FIBA 3x3 World Cup” тэмцээнд мөнгөн медаль хүртсэн Онолбаатарын Хулан нарт тус бүр 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийн урамшуулал олгож хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардлагатай 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д. ГҮРЭВ-ОЧИР



8325010857